


Шарын гол ХК (SHG.MSE)

Салбар: Уул Уурхай/Нүүрс

Хувьцааны үнэ



Үнэт цаасны үзүүлэлтүүд

| | |
|-------------------------------------|----------------|
| Симбол | SHG |
| Хувьцааны код | 309 |
| Нийт гаргасан хувьцаа (2012 он) | 10,231,389 |
| Зах зээлийн үнэ 2012.09.24 (төгрөг) | 10,000 |
| Зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг) | 102.3 |
| 52 долоо хоног- их/бага (төгрөг) | 11,500 / 8,800 |

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

| | 2010 | 2011 |
|---|-------|--------|
| Нийт хөрөнгө (тэрбум төгрөг) | 22.54 | 36.58 |
| Цэвэр ашиг (тэрбум төгрөг) | - | 0.42 |
| Биет бус хөрөнгө ба өр төлбөр (тэрбум төгрөг) | 14.74 | 4.51 |
| Эзэмшигчийн өмчийн дүн (тэрбум төгрөг) | 7.83 | 32.12 |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) | - | 41.19 |
| Үнэ ашгийн харьцаа (P/E) | n/a | 391.98 |
| Үнэ ба эзэмшигчийн өмчийн харьцаа (P/B) | 6.11 | 5.14 |
| Нийт хөрөнгийн өгөөж (ROA) | - | 0.01 |
| Эзэмшигчдийн өмчийн өгөөж (ROE) | - | 0.01 |
| Нэгж хувьцааны ногдол ашиг (DPS) | - | - |
| Ногдол ашгийн өгөөж | - | - |
| Дундаж хувьцааны үнэ (төгрөг) | 6,614 | 16,146 |
| Дундаж зах зээлийн үнэлгээ (тэрбум төгрөг) | 47.83 | 165.2 |

Эх сурвалж: Стандарт инвестмент ХХК

Судалгааг бичсэн:

Цэдэвдорж ЧИМГЭЭ,
Судалгааны багийн ахлагч
chimgee@standardinvestment.mn
Т +976 701 14433
М +976 99066293

Бямба МӨНХТУЯА,
Судалгааны ажилтан
munkhtuya@standardinvestment.mn
Т +976 701 14433
М +976 99027432

КОМПАНИЙН ТОЙМ

Танилцуулга

Шарын голын нүүрсний уурхай нь 1965 онд жилд 1.1 сая тонн чулуун нүүрс олборлож, 5 сая м³ хөрс хуулах хүчин чадалтайгаар байгуулагдсан. 1995 онд 723 сая төгрөгийн дүрмийн сантайгаар Шарын гол хувьцаат компани болон зохион байгуулагджээ. Нийт хувьцааны 80 хувь нь төрийн өмчид үлдэж, үлдсэн 20 хувь нь хөрөнгийн биржээр арилжаалагдсан байна. 2003 онд Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчийн мэдлийн хувьцааг хувьчлан, 100 хувийн хувьцаат компани болжээ. Тус уурхайн нүүрсний гол хэрэглэгч нь Дархан, Эрдэнэт, Сэлэнгийн дулааны цахилгааны станцууд юм. Шарын голын уурхайн Ашигт малтмалын газраас батлагдсан нөөцийн хэмжээ 146.3 сая тонн, харин хайгуулын ажлыг JORC стандартын дагуу явуулснаар хагас битумтай тослог нүүрсний нөөцийг 374 сая тонн гэж тодорхойлжээ. Уурхай нь 470 гаруй ажилчинтай.

Менежмент

| Хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо | Бүтэц |
|-------------------------------|---------------|-------|
| Firebird Mongolia Fund | 342,101 | 23% |
| Firebird Global Masterfund | 2,028,906 | 20% |
| Nihan Holding Sarl | 1,560,239 | 15% |
| Firebird Global Masterfund II | 1,142,674 | 11% |
| Mogul Resources INC | 1,000,000 | 10% |
| Шарын гол Энержо ХХК | 895,000 | 9% |
| Бусад | 1,262,469 | 12% |

Эх сурвалж: www.sharyngol.mn 2012/03/16


Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга – Б.Батмөнх

Ноён Батхүүгийн Батмөнх нь 1974 онд төрсөн. 1992-1996 онд МУИС-ийн Эдийн засгийн сургууль, 1998-2000 онд АНУ-ын Калифорнийн их сургууль тус тус төгссөн. Санхүүч, корпорацийн санхүүч мэргэжилтэй. Б.Батмөнх нь 1996 оноос Монгол банкны Мөнгөний бодлогын газарт эдийн засагч, 1996-1998 онд "Бодь лизинг санхүү" ХХК-д дэд захирал, 2000-2001 онд "Орикс Консалтинг" ХХК-д захирал, 2001-2008 онд "Би Энд Жи экьюпмент" ХХК-д захирал, 2008 оноос "Би Энд Жи" групп, Уул уурхайн салбарын ерөнхийлөгчөөр ажиллаж байсан. 2003 оноос одоог хүртэл "Шарын гол" ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байна.

Гүйцэтгэх захирал – С.Насанбат

Ноён Сундуйжавын Насанбат нь 1971 онд төрсөн. 1989 онд зах зээлийн коллеж, 2003 онд Орхон их сургуулийг төгссөн. Нийтийн хоолны ня-бо, эрх зүйч мэргэжилтэй. 2008 онд МАХН-аас нэр дэвшин аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон. Одоогоор Шарын гол ХК-ын гүйцэтгэх захирал үүргийг хашиж байна.

Зах зээлийн мэдээлэл



Монголын статистикийн мэдээллээр 2007-2011 оны хооронд дотоодын нийт нүүрс олборлолтын хэмжээ жилд 9.2-32 сая тонн, хувийн хэвшлийн уурхайн нүүрс олборлолт 3-20 сая тонн, төрийн өмчит уурхайн нүүрс олборлолт 6.2-12 сая тонн, дотоодын нүүрсний хэрэглээний хэмжээ жилд 5.9-6.8 сая тонн байжээ. Дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн эзлэх хувь 2011 оны байдлаар 26 хувьтай байна. Мөн 2011 онд нийт 32 сая тонн нүүрс олборлосноос эрчим хүчний зориулалттай нүүрсний хэмжээ 5.9 сая тонн байсан ба үүний 375.1 мян.тонн нь Шарын голын уурхайн олборлосон нүүрс байжээ. Шарын гол ХК-ийн нүүрс олборлолтын хэмжээний нийт нүүрс олборлолтод эзлэх хувь жил ирэх тусам багасаж байгаа нь бусад нүүрсний уурхайнуудын нүүрс олборлолтын хэмжээ эрс нэмэгдсэнтэй холбоотой болно.

Компанийн өсөлт, хөгжил

Шарын голын нүүрсний уурхай нь Улаанбаатар хотоос 215 км зайд, Дархан-Уул аймгийн Шарын гол суманд байрладаг. Тус уурхай нь төмөр замын үндсэн сүлжээнд 65 км төмөр замаар холбогдсоороо тээвэрлэлтийн зардлыг бууруулж чаджээ. Тус уурхай нь сардаа 50,000 тонн нүүрс олборлож, ихэвчлэн дотоодын хэрэгцээг хангадаг. Шарын голын нүүрсний чанар нь 2010 оны JORC стандартын дагуу хийсэн анализаар 3,600-5,083 ккал/кг илчлэгтэй, 2.21%-14.67% чийглэгтэй болох нь батлагдсан байна.

2010 онд “Firebird management” компани тус компанийн хувьцааны томоохон багцыг худалдан авч, хувьцаанд хөрвөх зээлийн санхүүжилт хийсэн байна. 2011.01.13-ны өдрийн СЗХ-ны шийдвэрээр 5.4 тэрбум төгрөгийн хөрвөх зээлийн санхүүжилтийг 1,292,596 ширхэг хувьцаанд хөрвүүлснээр, 2011.08.24-ний өдрийн СЗХ-ны шийдвэрээр 12.9 тэрбум төгрөгийн хөрвөх зээлийн санхүүжилтийг 1,707,404 ширхэг хувьцаа нэмж гаргаснаар компанийн нийт гаргасан хувьцааны тоо 10,231,389 болж дээрх хувьцааг арилжаанд оруулснаар нийт 18.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгожээ. Тус компанийн менежментийн багт олон улсын туршлагатай мэргэжилтнүүд ажиллаж байна. ТУЗ-ийн хурлаас гэрээт хэрэглэгчдэд 1 тонн нүүрсийг 2011.05.10-ны өдрөөс эхлэн 50,000 төгрөгөөр нийлүүлж харин эрчим хүчний нүүрсний үнийг ДЦС-уудад 1 тонн нь 26,275 төгрөгөөр нийлүүлсэн хэвээр байгаа ажээ. 23 сая тонн нөөцтэй Шаазгайтын ордыг ашиглах бэлтгэл ажил хангагдсан бөгөөд ашиглалт эхлэхэд (2012-2013 он) Монгол

Улсын хойд бүсийн нүүрсний хэрэгцээ бүрэн хангагдах боломжтой болно. 2012 онд 1,200 м³ хөрс хуулалт, 300 мян.тонн нүүрс олборлохоор төлөвлөсөн байна. Мөн ТУЗ-ийн дарга С.Насанбатын мэдээллэснээр олборлосон нүүрсээ угааж, экспортод гаргах төсөл боловсруулж байгаа болно.

Дүгнэлт

Шарын гол ХК 2011 онд 11.5 тэрбум төгрөгийн орлого олж, 11.1 тэрбум төгрөгийн зардал гаргасан ба 0.42 сая төгрөгийн ашигтай ажилласан. 2010 онд богино хугацаат өр төлбөр 11.6 тэрбум төгрөг байж, 10.2 тэрбум төгрөгөөр багасч, 2011 онд 1.5 тэрбум төгрөг болсон байна. Мөн хугацаанд 3 сая ширхэг хувьцааг шинээр нэмж гарган, зээлийн санхүүжилтийг хийсэнтэй холбоотойгоор эзэмшигчийн өмч 24 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн болно. Нэгж хувьцаанд ногдох ашиг 2011 онд 41.19 төгрөг байжээ. Үнэ ба ашгийн харьцаа (P/E) нь 2011 онд 392 байсан нь 2011 онд нүүрсний салбарын хувьцааны үнэ хэт өссөнтэй холбоотой. Үнэ ба эзэмшигчдийн өмчийн харьцаа (P/B) нь 2011 онд 5.14 байсан нь бусад нүүрсний салбар дахь хувьцаагт компаниудтай харьцуулахад тухайн компаний үйл ажиллагаа сайн байгааг харуулж байна. Нийт хөрөнгийн өгөөж (ROA) ба эзэмшигчдийн өмчийн өгөөж (RoE) нь 2011 онд тус тус 10 хувь байгаа нь нийт хөрөнгийг болон эзэмшигчийн өмчийг ашиглан 10 хувийн ашиг олж байгааг харуулж байгаа болно. Энэ нь ашиггүй ажилласан 2010 онтой харьцуулахад 2011 онд менежментийн өөрчлөлтийн үр дүн сайнаар нөлөөлснийг харуулж байна. Шарын гол ХК нь 1995 онд 0.95 төгрөгийн ногдол ашиг тарааснаас хойш дахин тараагаагүй байна.

